

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журмын дагуу бүрдүүлэх материал

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.hdc.gov.mn цахим хаягаар орж Эрүүл мэнд, спортын сайдын 2015.03.16-ны өдрийн 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг татан авч дэлгэрүүлэх шаардлагатай.

1. Дараах шалгуурыг хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргана:

- 1.1 Анагаах ухаан, сувилахуйн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
- 1.2 Зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичигтэй байх.
- 1.3 Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсаныг нотлох хүчин төгөлдөр баримт бичигтэй байх.
- 1.4 Тухайн төрөлжсөн мэргэшлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх.
- 1.5 Эрүүл мэндийн байгууллагын байнгын ажлын байранд ажиллах бол Монгол Улсын хууль тогтоомжид заасан тэтгэврийн насны хязгаарт байх.

2. Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж буй Монголын талын байгууллага нь гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг Монгол Улсад ирэхээс ажлын 20-иос доошгүй хоногийн өмнө дараах баримт бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Магадлан итгэмжлэл, лицензийн албанд ирүүлнэ.

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материалын жагсаалт

д/д	Бүрдүүлэх материалын жагсаалт	Тайлбар	Материалын бүрдэлт
1	Тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах хэрэгцээг тодорхойлсон албан бичиг	Зөвшөөрөл хүсч буй хугацаа, ажиллуулах хэрэгцээг дэлгэрэнгүй бичих.	
2	Гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө	Байгууллагын даргаар батлуулсан гарын үсэг, тамгатай байх.	
3	Байгууллагын эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар	Нотариатаар батлуулсан байх.	
4	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулга /энэхүү тушаалын наймдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу/	Байгууллагын даргын гарын үсэг, тамгатай байх.	
5	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний паспорт, түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Монгол Улсад оршин суух үнэмлэхтэй бол түүний хуулбарыг хамт авчрах.	
6	Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.	
7	Анагаах ухааны чиглэлээр боловсрол эзэмшсэнийг нотлох үнэмлэх, диплом түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.	

8	Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсаныг нотлох хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт	Тухайн улсын эрх бүхий байгууллагын Англи хэл дээрх хувилбар /тодорхойлолт/-ын хамт өгөх.	
9	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагуудын лавлагаа	- Визний ангилал харгалзахгүй бүх мэргэжилтэнд хамаарна. - ГИХГ, ХХҮЕГ, МХЕГ /зөвшөөрөл давтан хүссэн тохиолдолд/	
10	Энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасныг нотлох орчуулагчийн баримт бичгийн баталгаат хуулбар	- Тухайн хэлийг дээд түвшинд эзэмшсэн. - Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр орчуулга хийж байсан.	
11	Байгууллагын гадаад мэргэжилтэнтэй байгуулсан гэрээ /эсвэл байгууллага хоорондын-Засгийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь гадаадын мэргэжилтний үндсэн байгууллагатай урт хугацаагаар байгуулсан гэрээний хуулбар/	Журмын 3.3-т заасан нөхцлийг заавал тусгасан байх, зөвшөөрөл хүссэн хугацаанд хүчин төгөлдөр байх.	
12	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	Нотариатаар батлуулсан байх.	
13	Урьд нь лиценз авч байсан бол лицензийн хуулбар	Өмнөх лицензийг он оноор авчрах.	
14	Зөвшөөрлийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан	Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн өөрөө бичиж гарын үсэг зурсан байх /орчуулгын хамт/	
15	3x4 хэмжээтэй зураг 2%	Сүүлийн нэг жилийн хугацаанд авхуулсан байх.	

ЖИЧ: - Байгууллагын албан тоотод тухайн мэргэжилтний бүрдүүлсэн материалын хуудасны тоог тавьж танилцуулгын маягтыг хүн бүрээр гаргаж хавсаргасан байна.

- Тэмдэгтийн хураамж **120.000** төгрөгийг лиценз гарсны дараа төлж, баримтыг авчирч өгнө.

Татварын ерөнхий газраас тэмдэгтийн хураамж төлөх дансыг нэгтгэсэн тул та ТЕГ-ын www.mta.mn сайтын e-tax.mta.mn татварын цахим системд нэвтрэн Төлбөрийн даалгавар үүсгэх хэсгээр орж асуултуудыг бөглөн хадгалах товчийг дарснаар гарч ирэх 13 оронтой КОД-ыг авч аль ч банкинд очин төлөх боломжтой. /Татвар төлөгчийн Регистрийн дугаар хэсэгт лиценз хүссэн байгууллагын регистр, эсвэл тухайн гадаадын иргэний оршин суух үнэмлэхний дугаарыг бичнэ/

Төлбөрийн даалгавар үүсгэх

Регистрийн дугаараа хийгээд ТТД сонгох гэдгийг дарахад Овог нэр автоматаар гарч ирнэ.

Татвар төлөгчийн регистрийн дугаар ТТД сонгох

Улсын тэмдэгтийн хураамж 25: Сүхбаатар дүүрэг

Татварын төрөл Татварын алба

2598: Дүүргийн төвлөрсөн 9086331: Эрүүл мэндийн хөгжлийн төв

Сум, дүүрэг Төлбөр хүлээн авагч

Төлөх дүн Утас

Дараах тоог оруулна уу

Хүснэгтийг дээрх байдлаар бөглөөрэй

Эрүүл мэндийн хөгжлийн төв
Магадлан итгэмжлэл, лицензийн алба

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
98 дугаар тушаалын 8 дугаар
хавсралт


ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ТАНИЛЦУУЛГЫН МАЯГТ

Байгууллагын мэдээлэл:

1. Урьж буй байгууллагын нэр:
2. Урьж буй байгууллагын хаяг:
3. Урьж буй байгууллагын холбоо барих утас, хариуцах хүн /эмнэлгийн мэргэжилтний нэр:

Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээлэл:

1. Овог нэр:
2. Нас:
3. Хүйс:
4. Яс үндэс:
5. Үндсэн захиргаа:
6. Паспортын дугаар, хүчинтэй байх хугацаа:
7. Монгол улсад зорчихоор мэдүүлсэн визийн ангилал, төрөл:
8. Боловсрол зэрэг:
9. Төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зэрэг:
10. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, олгогдсон огноо, хүчинтэй хугацаа:
11. Урьд эрхэлж байсан ажил (он дарааллаар):
12. Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:
13. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл:
14. Үзүүлэх гэж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэл (дэлгэрэнгүй бичнэ, мэс заслын нэр, төрөл гэх мэт), үндэслэл:



Урьж буй байгууллагын дарга /нэр/

Гарын үсэг, тамга, тэмдэг